



**НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 12 сарын 23 өдөр

Дугаар

A/45

Улаанбаатар хот

Байгууллагын стратеги төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/637 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын 2015-2018 онуудад баримталж ажиллах стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг үйл ажиллагаандаа удирдлага болгож, чиг үүргийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөлтөд тусгаж ажиллахыг хэлтсийн дарга нарт даалгасугай.
3. Энэ тушаалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /С.Батсүх/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Я.БАЙГАЛМАА

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын даргын 2014 оны 12 сарын 23-ний өдрийн 1/1 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН 2015-2018 ОНЫ СТРАТЕГИ

Өмнөх үг

1. Алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зүйлс
 - 1.1. Тэргүүлэх чиглэл
 - 1.2. Орчны шинжилгээ
2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын стратеги
3. Стратегийн зорилтууд, хүрэх үр дүн
4. Стратегийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт
 - 4.1. Бүтэц, зохион байгуулалтын нэгжийн чиг үүргүүд
5. Түншлэл хамтын ажиллагаа
6. Гүйцэтгэлийн хяналт, мониторинг
7. Стратегийн санхүүжилт
 - 7.1. Санхүүгийн байдал
 - 7.2. Төсвийн төсөөлөл

Өмнөх үг

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас 2013 онд “Үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөр”-ийг боловсруулж Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/637 дугаар захирамжаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Газар нь 2013 онд орон тоо бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн болон батлагдсан дүрэм, журмын дагуу жил бүрийн Ерөнхий менежерээс Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний салшгүй хэсэг, байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахад баримтлах бодлогын чухал баримт бичиг боловсруулах шаардлага тавигдсан ба хэтийн зорилтоо шинээр боловсруулах, гадаад болон дотоод орчны нөхцөл байдлыг шинжилсний дагуу эрхэм зорилго, стратеги зорилтуудаа шинэчлэн тодорхойлж, бодлого төлөвлөлт, менежментийн арга хэлбэрийг өөрчлөх зорилтыг агуулсан стратеги зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх ажил үйлчилгээ, нэр томьёолол, арга хэлбэрийг шинэчлэн тодорхойлсон ирэх 4 жилийн үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.

Ирэх 4 жилд нийслэлийн хүүхэд, гэр бүлийн салбарт баримтлах стратегийн бодлого, зорилт, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны цөм нь өндөр хөгжилтэй орнуудын хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын шилдэг арга туршлагаас өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, тэдгээрийг үр ашигтай хэрэгжүүлэх, цаашид бие дааж тогтвортой хөгжих чадавх бүрдүүлэх замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд оршиж байгаа юм. Тиймээс ч өөрийн дотоод давуу чанар болон сул тал, гадаад эрсдэл болон боломжийг тодорхойлохдоо нийслэлд хүүхдийн байгууллага үүсэж бий болсноос хойшхи хугацаанд хуримтлуулсан арга туршлага, ололт амжилт, тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг бусад улс хотуудын түвшинтэй жиших замаар харьцуулж, дүгнэлт гаргасан.

Бид ирэх 4 жилийн хугацаанд тавьсан зорилтоо бүрэн шийдвэрлэснээр нийгмийн салбарын үйл ажиллагаанд олон улсын шилдэг арга туршлагад нийцсэн ажил үйлчилгээг нэвтрүүлэх, удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хариуцлагатай, нээлттэй, чадварлаг төрийн үйл ажиллагааг иргэд

үйлчлүүлэгчдэд хүргэх, гэр бүлд суурилсан хүүхдийн хөгжил, хамгааллыг хөгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулж чадна гэдэгт итгэлтэй байна.

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын болон салбарын өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг бодлого зорилтын хүрээнд дэмжүүлж, ажлыг эрчимжүүлэх, дуусгана.

Байгууллагын шинэчилсэн бүтэц, зохион байгуулалтын хүрээнд хэлтэс нэгжүүдээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг хуваарилж, шинэчлэн тогтооно.

Нийслэлийн хэмжээнд Хүүхэд, гэр бүлийн салбарт ажиллаж байгаа боловсон хүчнийг сургаж дадлагажуулах, салбарын хэмжээний бодлого, хөтөлбөр боловсруулж ажиллах зэрэг болно.

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ хүрээнд төрөөс хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын талаар явуулж буй бодлого шийдвэрийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж ирсэн.

Гэвч салбарын өмнө тулгамдаж байгаа асуудал цөөнгүй байна. Энэ цаг мөчид бид хурдсан хөгжиж буй нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцэх, хэрэгцээ шаардлагыг хангахуйц ажил үйлчилгээ, шинэлэг бүтээгдэхүүнийг үйлчлүүлэгчдэд хүргэх, төр засаг, байгууллага, албан тушаалтнуудаас үзүүлж буй итгэл, хүлээлтийг ханган биелүүлэхүйц хэмжээнд хүүхэд, гэр бүлийн салбарын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, эрчимжүүлэх нь чухал байна.

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР



Я.БАЙГАЛМАА

НЭГ.Алсын хараа, эрхэм зорилго, эрхэмлэх зүйлс, тэргүүлэх чиглэл

Алсын хараа: Нийслэлийн хүүхэд бүрийн сайн сайхны төлөө

Эрхэм зорилго: Хүүхдийн эрхэд суурилсан, ёс зүйг эрхэмлэсэн гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр, үйлчилгээг хөгжүүлэхэд чиглэнэ.

Үнэт зүйлс:

- Хүүхэд бүрийн төлөө:
- Хүүхдийг хайрлах сэтгэл:
- Хүүхдийн эрх ашиг:
- Хүүхдийн оролцоо:
- Ёс зүйтэй, хариуцлагатай, чадварлаг боловсон хүчин:
- Түншлэл, хамтын ажиллагаа:
- Гэр бүлд суурилсан үйлчилгээ:

1.1. Тэргүүлэх чиглэл:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцоо нийгмийн хамгааллын талаарх төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж хөтөлбөр төслийн хэрэгжилтийг хангуулах

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн мэдээлэл, судалгаа сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг өргөжүүлэх

Гэр бүл, хүүхэд хамгааллын урьдчилсан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх, үйлчилгээг хөгжүүлэх

Салбар дундын үйл ажиллагааг зохицуулах замаар хүүхэд, гэр бүлийн хөгжил оролцооны таатай орчин нөхцлийг бий болгох

1.2. Орчны шинжилгээ

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ:

Давуу тал

Газар нь өөрийн гэсэн бүрэн засвар хийсэн ажлын байртай.

Хүүхэд, гэр бүлийн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах хууль эрх зүйн орчин бүрдсэн, бие даасан хуультай, удирдлагын тогтолцоо нь хуулиар баталгаажсан,

Салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд нийслэлийн хэмжээнд хяналт тавих ажил тогтмолжсон,

Үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлж, хөтөлбөрийн нэгдүгээр шатны зорилтыг амжилттай хэрэгжүүлсэн, эрсдэлтэй хүүхдийн түвшин тогтоох баримтыг цахимжуулж, нэвтрүүлсэн,

Боловсон хүчний хувьд мэргэшсэн, туршлагатай хамт олон бүрдсэн,

Албан хаагчдын ажиллах орчин, материаллаг баазыг сайжруулсан.

Байгууллагын архивын 1986-2013 оны баримтад эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажил хийгдсэн, нэгдсэн бүртгэл, данс үйлдсэн, зааврын

Сул тал

Дүүрэг, хороонд хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэргэжлийн боловсон хүчин бүрэн хангагдаагүй, тэднийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах тогтолцоо бүрдээгүй,

Дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвүүд үйл ажиллагаа явуулах өөрийн гэсэн байргүй.

Төвийн ажилтнуудын цалин хангамж муу, төрийн үйлчилгээний албан хаагч нар байдаг

Байгууллагын батлагдсан төсөв хүрэлцдэггүй, ажилтнуудын сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хүндрэлтэй.

Бүтэц орон тоо батлагдсан боловч жилийн төсөв санхүүжилт нэмэгдээгүй, хүрэлцдэггүй, хуучнаараа батлагдсан.

дагуу хөтлөн явуулсан.
 Байгууллагын архивын
 1993-2012 оны
 захирамжлалын баримтыг
 цахимжуулж цахим архив
 үүсгэсэн.

		Боломж	Эрсдэл
Гадаад орчин		<p>Гадаад харилцаа хамтын ажиллагааг түшиглэн албан хаагчдыг урт богино хугацаагаар сургах, мэргэжилтэн урьж ирүүлэх замаар мэдээлэл авах, туршлага солилцох, Төсөл хэрэгжүүлэх замаар гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтийн дэмжлэгээр зохих дэмжлэг тусалцаа авах, Бүтэц орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнө нь хэрэгжиж байгаагүй болон дутуу хэрэгжиж ирсэн ажлуудыг хэрэгжүүлэх боломжтой болсон.</p>	<p>Хүүхдийн байгууллагын /нийгмийн салбарын/ төсөв санхүү бага Салбарын онцлогоос хамаараад төрийн үйлчилгээг бусад байгууллагууд /талууд/-тай хамтран хэрэгжүүлэх болдог, төрийн байгууллагын уялдаа холбоо муу. Сонгуулийн жилүүдэд аливаа зорилт, үйл ажиллагаа явуулдаг, үүнтэй холбоотойгоор төлөвлөсөн стратеги төлөвлөгөө бүрэн хэрэгжихгүй байх магадлалтай. Энэхүү стратегийг бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай</p>

ХОЁР. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын стратеги

а. Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь өөрийн зорилт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон энэхүү үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

Хүүхдийн эрхийн Конвенци
 Монгол Улсын Үндсэн хууль
 Төрийн албаны тухай хууль

Хөдөлмөрийн тухай хууль
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
Гэр бүлийн тухай хууль
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
Бусад холбогдох хууль тогтоомж зэрэг болно.

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын 2015-2018 оны хугацаанд хүрэхээр дэвшүүлж буй стратеги зорилтыг хэрэгжүүлэхдээ удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох үндсэн зарчмыг удирдлага болгоно.

б. Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэрэгцээ шаардлагад тулгуурлан Зорилтыг дараах үндсэн зорилт, хэрэгцээ шаардлагад нийцсэн дараах зорилтыг дэвшүүлсэн.

Нэгдүгээр зорилт: Хүүхдийн хөгжлийн үйлчилгээг үндэсний уламжлалтай хослуулан хөгжүүлнэ.

Хоёрдугаар зорилт: Гэр бүлд суурилсан хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.

Гуравдугаар зорилт: Олон нийтийн оролцоотой хүүхдийн эрхийн хяналтыг бий болгоно.

Дөрөвдүгээр зорилт: Эрсдэл, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлнэ.

Тавдугаар зорилт: Гэр бүл, хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн бие даасан байдлыг сайжруулна.

Зургаадугаар зорилт : Салбарын судалгаа, мэдээллийн санг баяжуулж, хяналт үнэлгээ, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлнэ.

Долоодугаар зорилт : Салбарын бодлого, төлөвлөлтийг удирдан зохион байгуулах замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүх түвшинд бүрэн хангуулна.

Байгууллагын бүтэц, орон тоо нэмэгдэж бүтцийн шинэ нэгжүүд бий болсон, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, ажлын цар хүрээ өргөжиж өмнө нь бүрэн хэрэгжүүлж чадаагүй ирсэн ажлуудаа хэрэгжүүлэх, шинэ техник технологи, ололт амжилтыг нэвтрүүлэх боловсон хүчний чадавхи, нөөц бололцоо бүрдсэн зэрэг болно.

ГУРАВ. Стратегийн зорилтууд буюу хүрэх үр дүн.

Газар нь нийслэлийн Засаг даргын шилжүүлсэн эрх мэдэл, хуульд заасан үндсэн дөрвөн чиг үүрэг болон энэхүү стратегийн долоон зорилтыг хэрэгжүүлнэ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын стратегийн зорилтууд (2015-2018 он)

Нэгдүгээр зорилт: Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг үндэсний уламжлалтай хослуулан хөгжүүлнэ.

Хоёрдугаар зорилт: Гэр бүлд суурилсан хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ.

Гуравдугаар зорилт: Олон нийтийн оролцоотой хүүхдийн эрхийн хяналтыг бий болгоно.

Дөрөвдүгээр зорилт: Эрсдэл, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлнэ.

Тавдугаар зорилт: Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн бие даасан байдлыг сайжруулна.

Зургаадугаар зорилт: Салбарын судалгаа, мэдээллийн санг баяжуулж, хяналт үнэлгээ, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлнэ.

Долоодугаар стратеги: Салбарын бодлого, төлөвлөлтийг удирдан зохион байгуулах замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүх түвшинд бүрэн хангуулна.

Стратегийн хүрэх үр дүн

Нэгдүгээр стратегийн зорилт: *Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн үйлчилгээг үндэсний уламжлалтай хослуулан хөгжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд:* Хүүхдийн хөгжлийн үйлчилгээг нийслэлийн хүүхэд бүрт хүргэх нөхцлийг бүрдүүлж, хүүхдийн

амралт, чөлөөт цагийн үйлчилгээний орчинг сайжруулж, хорооны түвшинд үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ. Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний стандарт, удирдамжийг боловсруулна. Түүнчлэн хүүхдийн бие бялдар, оюун санааны зөв хөгжил, боловсрол, хүмүүжлийн талаар олон нийтийн мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлнэ. Дээрх үйл ажиллагааг дараах зорилтуудаар хэрэгжүүлнэ.

Зорилт 1.1.1 Нийслэлийн Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Зорилт 1.1.2 Хүүхдийн эрхэд суурилсан зуслангийн үйлчилгээг дэмжиж, хүүхдийн амралт, чөлөөт цагийн үйлчилгээ, хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх, стандартын хэрэгжилтийг хангах, биеийн тамир спортын чөлөөт цагийн үйлчилгээг хөгжүүлнэ.

Зорилт 1.1.3 Соёл урлагийн үйлчилгээг үндэсний уламжлалтай хослуулан хөгжүүлнэ.

Зорилт 1.2.1 Гэр бүлийн боловсрол, хүүхдийн эерэг хүмүүжлийн талаарх нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Зорилт 1.2.2 Хүүхдийн хөгжил, аж төрөх ёсны талаар олон нийтийн зан үйлийг өөрчлөх нөлөөллийн үйл ажиллагааг хөгжүүлнэ.

Зорилт 1.3.1 Хүүхдийн оролцооны стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх чадавхийг хөгжүүлж, хүүхдэд ээлтэй орчин ба хүүхдийн оролцооны олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.

Хүрэх үр дүн:

2015. Нийслэлийн 5 хороонд хүүхдийн хөгжил, хамгааллын байрыг байгуулж, хүүхдийн хөгжлийн 2 үйлчилгээний удирдамж, стандартыг боловсруулж батлуулсан байна.

2016-2017. Нийслэлийн 10 хороонд хүүхдийн хөгжил, хамгааллын байрыг байгуулж, хүүхдийн тоглоомын талбайн стандартыг боловсронгуй болгож, түүний ашиглалт, засварыг хариуцах тогтолцоог бий болгосон байна. Нийслэлийн хороодын 30 хувьд хүүхдийн чөлөөт цагийн дугуйлан, секц ажиллуулна.

2017. Хүүхдийн оролцоо дээшилсэн байна.

Хоёрдугаар стратегийн зорилт: Гэр бүлд суурилсан хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх гэсэн зорилтын хүрээнд: Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтсийг, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газарт, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн

төвийг дүүрэгт, хүүхэд хамгааллын хамтарсан багийг хороонд ажиллуулна. Хүүхдийн хамгаалуулах эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, дэмжих үйлчилгээг хөгжүүлж, үйлчилгээний шинэ төрлүүдийг бий болгох, стандартыг боловсруулна. Энэхүү ажиллагаанууд дараах зорилтуудаар хэрэгжинэ.

Зорилт 2.1. Хүүхэд хамгааллын болон хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол түгээж, хүүхэд бүрийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдлаас сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Зорилт 2.2. Хүүхдийн эрх, хамгааллын зөрчлийн мэдээллийг хүлээн авах тогтолцоог бүрдүүлж, хүүхэд гэр бүлд чиглэсэн нийгэм-сэтгэлзүйн шуурхай тусламжийн үйлчилгээг хөгжүүлнэ.

Зорилт 2.3. Хамгаалал шаардлагатай хүүхдэд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллын тогтолцооны талуудын холбогдох хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.

Зорилт 2.4 Асрамж халамжийн байгууллагад хүүхэд түүний гэр бүлд түшиглэсэн хувилбарт үйлчилгээг түгээж, хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх дэмжих чиглэлийг хөгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

2015-2016. Хүүхэд хамгааллын 5 төрлийн үйлчилгээг хүргэх орчин бүрдсэн байна.

2016-2017. Хүүхэд бүр хамгааллын үр дүнтэй, чанартай үйлчилгээ авдаг болсон байна.

Хамтын ажиллагаа бэхжиж, үйлчилгээний чанар дээшилсэн байна. Хүүхэд хамгааллын шинэ бүтцийг байгуулсан байна.

Гуравдугаар стратегийн зорилт : *Олон нийтийн оролцоотой хүүхдийн эрхийн хяналтыг бий болгох гэсэн зорилтын хүрээнд:* Гэр бүл, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, олон нийтийн үйлчилгээ болон хүүхдийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хүүхдийн эрхийн хяналт тавих олон нийтийн оролцоог хангаж, үр дүнг мэдээлэх, мэдээллийн дагуу захиргааны арга хэмжээ авах тогтолцоог дараах зорилтуудаар хөгжүүлнэ.

Зорилт 3.1 Хүүхдийн эрхийн хяналтын хэм хэмжээ, зохицуулалтыг боловсронгуй болгох хараа хяналтгүй хүүхдийн эрхийн хяналтыг

сайжруулна.

Зорилт 3.2 Эрүүл мэнд, зам тээвэр, боловсрол, нийтийн үйлчилгээний зэрэг салбар байгууллагад хүүхдийн эрхийн хяналтыг сайжруулна.

Зорилт 3.3 Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл судалгаар хангах

Хүрэх үр дүн:

2015. 6000 хүүхэд, залуучууд гэр бүл архи тамхи мансууруулах бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чадвартай болсон байна.

3000 хүүхэд өөрийгөө болон бусдыг гэмт хэрэгт холбогдоос урьдчилэн сэргийлэх чадвартай болсон

Хүүхдийг зам тээврийн ослын чиглэлээр талуудтай 1-2 удаагийн уулзалт хийгдэж, ажлын хэсэг байгуулагдаж, үйл ажиллагааны стратеги боловсруулагдсан байна.

Холбогдох хууль тогтоомжид санал өгч, хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зөвлөмж гарсан байна.

2015-2016. Энэ бүх салбарт хүүхдийн эрхийн хяналтыг сайжруулах арга зүйг боловсруулах, судалгаа хийх, холбогдох шийдвэрүүдийг гаргах

2016-2017. Салбар байгууллагуудын хүүхдийн эрхийн хяналт сайжирч, хүүхдэд хүрэх үйлчилгээ чанаржина.

Дөрөвдүгээр стратегийн зорилт : *Эрсдэл, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд:* Эрсдэл, осол гамшиг, зөрчлийн үед хүүхдийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, шаардлагатай нөхцөлд шуурхай тусламж, үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог дараах зорилтуудын хүрээнд хөгжүүлнэ.

Зорилт 4.1 Байгалийн болон нийтийг хамарсан гамшгийн үед нийслэлийн хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

Зорилт 4.2 Байгалийн болон нийтийг хамарсан гамшгийн үед ажиллах тогтолцоог хөгжүүлнэ.

Зорилт 4.3 Сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдэд осол, гамшгаас хамгаалах нөлөөллийн ажлыг холбогдох

байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

2015. Нийслэлийн хүүхдийг осол гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гарын авлагыг боловсруулсан байна.

2016. Хүүхдэд осол гамшгаас өөрийгөө хамгаалых мэдлэг олгож, нийт хүүхдийн 30 хувийг хамруулсан дадлага, сургуулилтыг хийдэг болсон байна.

Тавдугаар стратегийн зорилт: *Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн бие даасан байдлыг сайжруулна гэсэн зорилтын хүрээнд:* Нийслэлийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчинг сайжруулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа нэмэгдүүлнэ. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний бие даасан санхүүжилтын тогтолцоо бий болгох, нийслэлийн хэмжээнд санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ. Эдгээр үйл ажиллагааг дараах зорилтын хүрээнд шийдвэрлэнэ.

Зорилт 5.1 Нийслэлийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний журмыг боловсруулж, эрх зүй зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.

Зорилт 5.2 Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн бие даасан байдлыг хангана.

Хүрэх үр дүн:

2015 Хүүхдийн байгууллагын бүр түвшинд хүүхдийн хөгжил хамгааллын санхүүжилтийн бие даасан тогтолцооны зарим хэсгийг бий болгосон байна.

2016. Нийслэлийн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, стандартууд шинэчлэгдэж, боловсрогдсон байна. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн бие даасан тогтолцоо бий болсон байна.

2017. Хууль тогтоомж, заавар журмууд мөрдөгдөж үр дүнгээ өгсөн байна. Санхүүжилтийн бие даасан тогтолцооны нөхцөл бүрдэж, үр дүнгээ өгч эхэлсэн байна.

ургаадугаар стратегийн зорилт: *Салбарын судалгаа, мэдээллийн санг баяжуулж, хяналт үнэлгээ, мэдээллийн ил тод байдлыг хэрэгжүүлнэ гэсэн зорилтын хүрээнд:* Нийслэл, газрын хэмжээнд шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл судалгаагаар хангах, үйл ажиллагааны ил тод байдлыг цахим хуудас, портал сайт, ном товхимол, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх, үйл ажиллагааны төлөвлөлт, түүний хэрэгжилтэнд үнэлгээ хийж, зөвлөмж гарган мэдээлэх, хүүхдийн чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрүүдийн гүйцэтгэл тайланд хяналт, үнэлгээ хийж зөвлөмж гаргаж, мэдээлэхэд дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ.

Зорилт 6.1 Мэдээллийн үйл ажиллагааны ил тод байдал:

Зорилт 6.2 Хэрэглэгчийн үнэлгээ

Зорилт 6.3 Судалгаа мэдээллийн сан, хэвлэл мэдээлэл, хяналт үнэлгээг сайжруулна.

Хүрэх үр дүн:

2016-2018 Хүүхдийн асуудлаарх мэдээлэл, судалгааны сан бүрдэлт сайжирсан байна.

Долоодугаар стратегийн зорилт : *Салбарын бодлого, төлөвлөлтийг удирдан зохион байгуулах замаар хүний нөөцийн чадавхийг дээшлүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна гэсэн зорилтын хүрээнд:* Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг явуулж чадварлаг албан хаагчдаар төрийн үйлчилгээг үзүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж хүүхдийн байгууллагыг дотоод ажлыг сайжруулахад дараах зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ:

Зорилт 7.1 Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, талуудтай хамтран хэрэгжүүлнэ

Зорилт 7.2 Байгууллагын бодлогын зорилтыг хэрэгжүүлнэ

Зорилт 7.3 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийг хэрэгжүүлнэ.

Зорилт 7.4 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хэрэгжүүлнэ.

Зорилт 7.5. Шинэ санаачилга, үр дүнг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

2015. Салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулагдсан байна.

2015. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн төсвийг батлуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.

2015-2020 Хүний нөөцийн хөгжлийн иж бүрэн, шинэ тогтолцоотой болж, салбарын албан хаагчид чадавхижиж, төрийн үйлчилгээг мэргэшсэн төрийн албан хаагчид хүргэдэг болсон байна. Стратегийн жилүүдэд хэрэгжүүлнэ.

2015-2018 Байгууллагын бодлогын зорилт, дүрмээр хүлээсэн үүрэг, үйл ажиллагааны ил тод байдал, шинэ саначлага үр дүнд хүрсэн байна. Стратегийн жилүүдэд хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. Стратегийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь нийслэлийн Засаг даргын 2013 оны А/637 дугаар захирамжаар бүтэц орон тоо, дүрмээ шинэчлэн батлуулж 4 хэлтэс 32 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан, нийслэлийн хэмжээнд гэр бүлд суурилсан хөгжил, хамгааллын үйлчилгээг дүүргийн дэргэдэх Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төвүүдээрээ дамжуулан иргэдэд үзүүлж байна. Үүнд:

1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс
2. Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтэс
3. Мэдээлэл судалгаа, хяналт үнэлгээний хэлтэс
4. Захиргаа удирдлагын хэлтэс

4.1. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, зохион байгуулалтын нэгжүүдийн чиг үүрэг

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудлаарх төрийн бодлого, хууль тогтоомж, дүрэм, журам, холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон өөрийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж сурталчлах, орон нутгийн болон өөрийн удирдлагын байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих замаар гэр бүл,

нийгмийг хөгжлийн таатай орчин болгоход чиглэсэн мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлж төр, хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг хөгжүүлнэ.

Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтэс

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, тогтоомж, дүрэм, журам, холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон өөрийн байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, аливаа эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрх ашиг хохирч, зөрчигдсөн үед үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгоход талуудтай хамтран ажиллаж оновчтой, үр дүнтэй үйлчилгээ, тусламж, дэмжлэгийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Мэдээлэл судалгаа, хяналт үнэлгээний хэлтэс

Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянах мэдээлэл, судалгааны дэвшилтэт технологиуд суурилсан хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллыг сайжруулах бодлого, шийдвэрт нөлөөлөхүйц санг бий болгож, үйлчилгээний үр дүнг нийтэд хүртээмжтэй, ил тод мэдээлэх замаар олон нийтийн хяналтын тогтолцоог төлөвшүүлнэ.

Захиргаа удирдлагын хэлтэс

Байгууллагын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү бүртгэл, төсвийн зарцуулалт, түүний гүйцэтгэлд хяналт тавих, хөрөнгө оруулалтыг сайжруулах, албан хаагчдад нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх замаар хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, удирдлагын манлайллыг хангаж, ил тод, авилга, хүнд сурталгүй үйлчилгээ, харилцааг төлөвшүүлж ажиллана.

ТАВ. Түншлэл хамтын ажиллагаа

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд олон улсын болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай түншлэл хамтын ажиллагааг тогтвортой хөгжүүлнэ.

Олон улсын байгууллагатай хамтран ажиллахад баримтлах зарчим

Монгол Улсад хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагуудтай хамтран ажиллахдаа Хүүхдийн эрхийн конвенц болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиудыг сахиж мөрдөх болно. Ялангуяа хүүхдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэх асуудал нь түншлэл, хамтын ажиллагааны үндэс болно. Түүнчлэн түншлэл, хамтын ажиллагаа нь МУ-ын ЗГ, Нийслэлийн Засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын хэрэгжүүлж байгаа бодлого, стратегитай уялдсан байх болно. Эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг стратегийн хугацаанд хангах зорилгоор олон улсын байгууллагатай түншилж ажиллах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь ОУ-ын байгууллагаас техник, санхүүгийн туслалцаа авах чиглэлтэй байна. Техникийн туслалцааны хүрээнд хүний нөөцөө чадваржуулахаар ОУ-ын сургагч багш нараас сургалт авах болон гадаадын орнуудад сургаж, чадваржуулах, шинжлэх ухааны сүүлийн үеийн судалгааны материалуудыг авч ашиглах, ОУ-ын хурал, сургалтуудад оролцох ажлуудыг чухалчилж ажиллана.

Санхүүгийн дэмжлэгийн хувьд хүүхдийн хөгжил, хамгааллын тогтолцооны үйл ажиллагааны 30-аас доошгүй хувийг ОУ-ын байгууллагууд тогтмол санхүүжүүлэх тогтвортой харилцааг бий болгож ажиллана.

Хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахад баримтлах зарчим

Сүүлийн жилүүдэд гэр бүлд суурилсан хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг хувийн хэвшлийн болон дотоодын төрийн бус байгууллагууд хүргэх туршлага өргөжиж байна. Эдгээр байгууллагууд нь хүүхдийн хөгжил, хамгааллын олон талт үйлчилгээний хэлбэр, арга зүйг хөгжүүлэхийн хамт, хүүхэд үйлчилгээг хүртэх боломж нөхцөл сайжирч байгаа нь сайшаалтай. Цаашид эдгээр байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд тухайн үйлчилгээний стандарт, удирдамжийг боловсруулж, мөрдөж хэвших нь чухал. Байгууллагатай хүүхдийн хөгжил, хамгааллын төрийн зарим үйлчилгээг гэрээлэхийн тулд ТББ-дын чадавхийг үнэлэх, тэдэнэ тавих шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулан сонгож, тодорхой хугацаанд гэрээ байгуулна. Гэрээлсэн ажлын санхүүжилтийг 100% эсхүл 80-аас доошгүй хувийг төсвөөс санхүүжүүлнэ. Эдгээр байгууллагуудын чадавхи, арга барилыг хөгжүүлэх, өрсөлдөөнийг бий болгоход анхаарна.

Түншлэл, хамтын ажиллагааны хэлбэрүүд

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар нь бүх төрлийн үйлчилгээг бие даан хүргэх нөөц, боломж бага юм. Түүнчлэн хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнүүд хөгжөөгүй өнөөгийн нөхцөлд шинэ төрлийн үйлчилгээг бий болгох, үйлчилгээг хүргэх бүтэц, чадавхийг анхан шатны нэгжүүдэд хөгжүүлэхэд олон хэлбэр, арга зүйг ашиглах шаардлагатай. Монгол Улс эдийн засгийн шилжилтийн үед бие даасан бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс илүүтэй олон улсын байгууллагуудтай хамтран тодорхой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан. Сүүлийн жилүүдэд энэ байдалд ихээхэн өөрчлөлт гарч хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг гэрээгээр хэрэгжүүлэхэд анхаарах боллоо.

Хөтөлбөр, төсөл хамтран хэрэгжүүлэх

Энэ хэлбэр нь хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх, шинэ арга зүй, хэлбэрийг турших, холбогдох ажилтнуудынхаа ур чадварыг хөгжүүлэх боломжийг олгодог сайн талтай. Хөтөлбөр, төслийг хамтран хэрэгжүүлэхдээ нийслэлийн зүгээс хэрэгжүүлж байгаа хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын бодлогуудтай уялдуулах, хөтөлбөр, төслийн баримт бичгийг хамтран боловсруулах, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгоход илүү анхаарах нь чухал байдаг.

Гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Хүүхдийн төлөө газар хүүхдийн хөгжлийн болон хамгааллын үйлчилгээг хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж ажилладаг. Энэ үйл ажиллагааг боловсронгуй болгож, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд үйлчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгох, оролцогч талуудын чадавхийг хөгжүүлэх, гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, гэрээ байгуулах ур чадварыг сайжруулах асуудлууд гарч байна. Түүнчлэн жил бүр нийслэлийн Засаг даргатай хамтран нийслэлийн төсөвт шаардлагатай хөрөнгийг тусгах, гэрээгээр гүйцэтгүүлэх ажлын жагсаалтыг гаргаж зарлах ажлуудыг зохион байгуулна.

ЗУРГАА. Гүйцэтгэлийн хяналт, мониторинг

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын гүйцэтгэлийн хяналт, мониторинг нь гадна талаас хийх болон дотоод хяналт гэсэн хоёр үндсэн хэлбэрээр явагдана. Гадна талаас хийх хяналт нь дээд шатны болон мэргэжлийн байгууллагын хяналт мөн иргэд, олон нийтийн хяналт гэсэн хэлбэртэй байна. Дээд шатны болон мэргэжлийн байгууллагын хяналт нь Төрийн аудитын тухай, Мэргэжлийн хяналтын тухай болон бусад холбогдох хуулиудаар зохицуулагдсан байна.

Харин олон нийтийн хяналт нь Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолд “Хэрэглэгчийн үнэлгээг нийслэлийн Засаг даргаас иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн нийслэлийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргана” гэж заасан заалтын дагуу хийгдэнэ.

Байгууллагын гүйцэтгэлийн дотоод хяналт, мониторингийг Засгийн газрын 2011 оны 322 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А\1146 дугаар захирамжийн дагуу, байгууллагын дүрэм, бусад аргачлалын дагуу явуулна. Гүйцэтгэлийн дотоод хяналт, мониторингийн чиглэлээр нэгдсэн арга зүйн сургалт, аргачлалыг боловсруулж ашиглана.

ДОЛОО. Стратегийн санхүүжилт

7.1 Санхүү байдал

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын урсгал зардлын төсөв нь Төсвийн тухай болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд улсын төсөвт сууж өгдөг. Байгууллагын төсөв нь захиргааны болон үйлчилгээний зардлаас бүрдэж байна. Өнөөгийн практикаар захиргааны зардал нийт төсвийн дийлэнх хувийг эзлэж байна. Захиргааны зардалд ажилтнуудын цалин, татвар, шимтгэл, дулаан, цахилгаан, бичиг хэргийн болон унааны зэрэг зардлууд багтана. Үйлчилгээний зардалд тодорхой төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал орно.

Цаашид хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох шаардлага гарч

байна. Юуны өмнө эдгээр үйлчилгээний зардлын жишиг хэмжээг тогтооно.

Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхдийн төлөө санг ажиллуулах эрх зүйн үндэслэлтэй байна. Иймд хүүхдийн төлөө сангийн үйл ажиллагааг хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээг санхүүжүүлдэг хэлбэрт оруулах боломжийг судлах хэрэгтэй.

Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас хэрэгжүүлэх гэр бүлд суурилсан хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний зардал нь НХГБХГ-ын төсөв, хөтөлбөрийн төсөв, Засгийн Газрын Тусгай сангийн Хүүхдийн төлөө сан, олон улсын байгууллагын санхүүжилт, ашгийн байгууллагын хандив, санхүүжилт, салбар тус бүрийн үйл ажиллагааны санхүүжилт, цаашилбал Нийслэлийн хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөс бүрдэнэ.

Дүүрэг, хороодын хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээний зардал нь дүүргийн Засаг даргын төсөв, нөөц хөрөнгө, олон улсын байгууллагын санхүүжилт, ашгийн байгууллагын хандив, санхүүжилт, салбар тус бүрийн үйл ажиллагааны санхүүжилтээс бүрдэнэ.

7.2 Стратегийн төсвийн төсөөлөл

НХГБХГ-ын 2014-2017 оны төсвийн төсөөлөл

Үзүүлэлт	2014 он	Төсвийн төслийн санал, таамаглал		
	Батлагдсан төсөв	2015 он	2016 он	2017 он
I. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	290,226.0	621,088.6	654,169.2	676,815.4
II. Нийт зарлагын дүн	290,226.0	621,088.6	654,169.2	676,815.4
III. Урсгал зардлын дүн	290,226.0	621,088.6	654,169.2	676,815.4
Бараа, үйлчилгээний зардал	262,190.6	614,288.6	646,269.2	668,915.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	182,228.6	293,305.0	304,738.0	325,140.0
Үндсэн цалин	175,364.6	268,750.0	278,540.0	294,630.0

Унаа, хоолны хөнгөлөлт	6,864.0	24,555.0	26,198.0	30,510.0
Ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл	20,086.4	32,263.6	33,521.2	35,765.4
Тэтгэвэрийн даатгал	12,784.9	20,531.4	21,331.7	22,759.8
Тэтгэмжийн даатгал	1,457.8	1,466.5	1,523.7	1,625.7
ҮОМШ өвчний даатгал	1,826.4	2,933.1	3,047.4	3,251.4
Ажилгүйдлийн даатгал	364.5	1,466.5	1,523.7	1,625.7
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,652.8	5,866.1	6,094.8	6,502.8
Бараа, үйлчилгээний бусад зардал	59,875.4	288,720.0	308,010.0	308,010.0
Бичиг хэрэг	2,500.0	8,940.0	9,680.0	9,680.0
Гэрэл цахилгаан				
Түлш, халаалт				
Тээвэр (шатахуун)	7,150.0	11,300.0	13,100.0	13,100.0
Шуудан, холбоо	5,002.4	6,300.0	7,600.0	7,600.0
Цэвэр, бохир ус				
Дотоод албан томилолт	871.0	3,900.0	4,800.0	4,800.0
Гадаад албан томилолт		10,800.0	12,600.0	12,600.0
Ном, хэвлэл авах	500.0	1,300.0	2,000.0	2,000.0
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлага хийх		15,150.0	16,500.0	16,500.0
Эд хогшил худалдан авах	2,000.0	8,950.0	9,980.0	9,980.0
Үүнээс: Тавилга эд хогшил	1,000.0	4,950.0	4,980.0	4,980.0
Програм хангамаж	1,000.0	4,000.0	5,000.0	5,000.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000.0	4,600.0	5,800.0	5,800.0
Бусад зардал				

Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	21,810.4	6,980.0	8,350.0	8,350.0
Урсгал засвар	9,800.0	10,600.0	12,800.0	12,800.0
Төлбөр хураамж болон бусад зардал	6,191.6	6,000.0	6,500.0	6,500.0
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	1,550.0	2,500.0	3,000.0	3,000.0
Байрны түрээсийн хөлс	1,500.0	1,500.0	1,500.0	1,500.0
Бусад				
Бусад төвлөрсөн арга хэмжээ		193,900.0	198,500.0	198,500.0
Татаас ба урсгал шилжүүлэг		6,800.0	7,900.0	7,900.0
Өрх гэрт олгох шилжүүлэг		6,800.0	7,900.0	7,900.0
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		6,800.0	7,900.0	7,900.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	28,035.4	28,035.4	28,035.4	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр :	290,226.0	621,088.6	654,169.2	676,815.4
Төрийн өмч түрээслүүлсний орлого	6,800.0			
Төсвөөс санхүүжих	283,426.0	621,088.6	654,169.2	676,815.4
Байгууллагын тоо	1	1	1	1
Ажиллагсад бүгд	26	32	32	32
Удирдах ажилтан	1	1	1	1
Гүйцэтгэх ажилтан	12	29	29	29
Үйлчлэх ажилтан	13	2	2	2
Гэрээт ажилтан	-	-	-	-